



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠑ оны ᠒᠐ сарын ᠒᠑ өдөр

Дугаар ᠕1᠒68

Улаанбаатар хот

### Нийслэлийн хүүхдийн 84 дүгээр цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,407,750.00 (таван сая дөрвөн зуун долоон мянга долоон зуун тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн ерөнхий боловсролын 151 дүгээр сургуульд хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн хүүхдийн 84 дүгээр цэцэрлэг (Д.Сүрэнхорлоо)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 151 дүгээр сургууль (П.Хувьзаяа)-д, Нийслэлийн хүүхдийн 84 дүгээр цэцэрлэг (Д.Сүрэнхорлоо)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.


ДАРГА



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 10 дүгээр сарын 10-ны өдрийн А/48 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн хүүхдийн 84 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт-анд орсон	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
						нэгж үнэ	нийт үнэ			
1	Багш ширээ	2024.04.30	сайн	ш	5	1,081,550.00	5,407,750.00	865,240.02	4,542,509.98	Нийслэлийн ерөнхий боловсролын 151 дүгээр сургууль
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн							5,407,750.00	865,240.02	4,542,509.98	